

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
УЛААН ЗАГАЛМАЙН ХОРООНЫ 2014 ОНД
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2014 оны 11 дүгээр сарын 25

Эмээл толгой

Тус сумын Улаан Загалмайн хороо нь аймгийн Улаан Загалмайн хорооноос өгсөн чиглэл үүрэг даалгаврыг биелүүлэх, өөрийн сумын УЗН-ийн хорооны ажлын төлөвлөгөөг үндэслэн үйл ажиллагаагаа явуулж байна.

2014 онд МУЗН-ийн татвар төлөгч гишүүдийн татварын орлого 1446,0 /нэг сая дөрвөн зуун дөчин зургаан мянга/ төгрөгийг аймгийн Улаан Загалмайн хорооны дансанд шилжүүлж, татварын төлөвлөгөөг 144 хувиар давуулан биелүүлсэн байна.

Энэрэнгүй үйлсийн ач холбогдлыг иргэдэд тайлбарлан таниулсны үр дүнд Улаан Загалмайн нийгэмлэгийн онцгой гишүүн Ж.Рагчаасүрэн 2 дугаар багийн 2 иргэнийг тус бүр 14 хониор малжуулсан. Мөн 2 дугаар багийн малчин Төмөрийн Уртнасан нь тус сумын 4 дүгээр багийн иргэн З.Балдандоржийг 20 бог малаар, 2 дугаар багийн иргэн Алтангэрэлийн Энхбаатар нь 2 дугаар багийн иргэн Д.Мэндбаярыг 10 бог малаар буцалтгүй тусламж үзүүлж малжуулсан.

Гишүүд, сайн дурын идэвхтнүүдийн бүртгэлийг шинэчлэн гаргаж, мэдээллийн санг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар төсөвт байгууллагуудын нийт 148 гишүүдэд үнэмлэх бичиж өгсөн.

-МУЗН-ийн үйл ажиллагааг сурталчлах, гишүүд, дэмжигчдийн эгнээг өргөжүүлэх зорилгоор ухуулга сурталчилгаа хийж ажилласны үр дүнд 1-р багийн иргэн Бавуугийн Бүлтүүз, Адъяасүрэнгийн Ганболд, Шархүүхэний Цэвээнхүүхэн нар Улаан Загалмайн Нийгэмлэгийн Онцгой гишүүнээр элсэж, татвараа тушаасан.

Гамшигийн сангаас иргэний хамгаалалтын хувцас АСГАТЫН УУЛЗВАР ХХК нийлүүлсэн. Өвлийн бэлтгэл хангах хадлан тэжээл бэлтгэхэд 700 ширхэг өвс ЖАРГАЛАНТ СУМБЭН ЦАЦАЛ ХХК-С худалдаж авсан.

-Мөн сумын Улаан загалмайн хороо гишүүдийнхээ эгнээг өргөжүүлж шинээр Д.Пагмасүрэн, Ц.Сарантуяа, С.Жаргалсайхан, Х.Эрдэнэбилэг, Уранчимэг, Д.Түмэнжаргал, Н.Оюунчимэг нарыг "Сайн дурын идэвхтэн" -ээр элсүүлсэн. Сайн дурын идэвхтнүүдэд сумын төсвийн байгууллагуудыг хуваарилан өгч, Монголын Улаан загамлмай нийгэмлэгийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах чиглэлээр сургалт зохион байгуулсан.

“Аюулгүй цус эхчүүдийг аварна” уриан дор цусны донорын дэлхийн өдрийг тохиолдуулан сум дундын эмнэлэгтэй хамтарч ажлын төлөвлөгөө гарган дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

-Төлөвлөгөөний дагуу 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Донор гэж бэ? “Цусны донор болсноор ямар үүрэг хүлээн эрх эдлэх вэ?” гэсэн сэдвүүдээр 48 иргэнд сургалт хийн гарын авлага тарааснаас 28 иргэн цусны бүлэг тодорхойлуулж, шинээр 5 донор элсүүлсэн.

-Төрийн албан хаагчдын дунд “Аюулгүй цус эхийн амь насыг аварна” сэдэвт өдөрлөг зохион байгуулж нийт 59 хүн хамрагдсанаас 21 хүн элэгний ВС вирус илрүүлэх шинжилгээнд хамруулсан.

-2014 оны 06 дугаар сарын 14-ны өдөр цусаа бэлэгч донорууддаа хүндэтгэл үзүүлэн Я.Цогтбаатар, С.Сарантуяа, М.Сайнбилэг, Л.Ууганбаяр, С.Батжаргал нарыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.

-Цусны Донорын эгнээг өргөжүүлэхэд анхаарч ажиллан Хүндэт донорын болзол хангасан Х.Уранчимэгийн тодорхойлолтыг аймгийн Улаан Загалмайн хороонд хүргүүлсэн.

Улаан Загалмайн хорооны үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажилладаг Байдраг ахлах сургуулийн захирал З.Өнөржаргалыг “Тэргүүний залуу” алтан медалиар шагнуулсан.

-Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн 75 жилийн ойг угтаж, нийгмийн сайн сайхны төлөө хүмүүнлэгийн үйл ажиллагааг сурталчлах, өргөжүүлэх, гишүүд, дэмжигчид, хандивлагчдыг идэвхжүүлэх зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаан Загалмайн хорооноос “Хүмүүнлэгийн 7 хоногийн аян”-ны удирдамж гарган сумын бүх байгууллага, баг, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад хүргүүлж, хамтарч ажилласан.

-Энэхүү аяны хүрээнд сумын ИТХ, Засаг даргын Тамгын газрын хамт олон

Бусдын сайн сайхны төлөө ядарч зүдэрсэн үед нь сэтгэл санаа, эд материалын тусламж үзүүлэх зорилгоор тус сумын 4 дүгээр багийн иргэн, өрх толгойлсон эмэгтэй С.Жавзаннамжилд сумын ИТХ, Засаг даргын Тамгын газрын хамт /25 ажилтан/ олон нэг шуудай нүүрс, нэг машин аргал түүж өгсөн. /Орон нутгийн ханшаар 185,0 төгрөг/

Байдраг ахлах сургуулиас зохион байгуулж буй “Сайхан сэтгэлийн үзүүрт” хандивын аянд нэгдэж Засаг даргын Тамгын газрын ажилчдаас 95,0 төгрөг хандивласан.

Хүмүүнлэгийн 7 хоногийн аяны хүрээнд Байдраг ахлах сургууль

-Жаргалант сумын иргэн Төгсгэрэл овогтой Амгаланбаярын эмчилгээний зориулж “Сайхан сэтгэлийн үзүүрт” хандивын аяныг зохион байгуулсан. Хандивын аянд Засаг даргын Тамгын газар, Цэцэрлэг, Байдраг ахлах сургууль, Соёлын төв, Хаан банк зэрэг байгууллагууд нэгдэж нийт 635,0 төгрөгийн хандив цуглуулан хүлээлгэн өгсөн.

-Эрдмийн баярын нээлтийн үеэр 1-12 дугаар ангийн 16 сурагчдад сумын аж ахуйн нэгж, байгууллагуудаар ивээн тэтгүүлэн хичээлийн хэрэгсэл өгүүлсэн.

“Хариу нэхээгүй тус” аяны хүрээнд ахмад настанд тусалж, тэдэнд ээлтэй орчин бий болгох, тулгамдаж буй асуудалд нь туслах, мөн сургуулийн насны нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Тус аянд 3-12 дугаар ангийн 16 бүлэг оролцохоос 7 бүлэг оролцож амжилттай зохион байгуулагдлаа. Үүнд: 1-р байранд Г.Энхцэцэг багштай 10б анги хамт олон Өргөмжлөл, Шилжин явах цом, Ус буцалгагчаар шагнуулсан. 2-р байранд О. Оюун багштай 11а анги хамт олон Өргөмжлөл, Ханийн цагаар шагнууллаа. 3-р байранд Б. Ууганцэцэг багштай 10а ангийн хамт олон Өргөмжлөл, ханийн цагаар тус тус шагнууллаа.

Нийт оролцсон ангиудыг дэлгэрүүлбэл:

- ✚ Д.Амардэлгэр багштай 6а анги нь өндөр настан Пүрэвсүрэн гуайд аргал түүж өгөх, гэр орныг цэвэрлэх, ус авч өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- ✚ Г.Батдулам багштай 6б анги нь өндөр настан Д.Сандагсүрэн гуайн хашааны хог цэвэрлэх, гэрийн ажилд туслах, ус авах зэрэг ажил хийж ахмадын үгийг сонсож, сэтгэгдлийг нь хуваалцлаа.
- ✚ Д.Алтанцэцэг багштай 7а анги нь өндөр настан Түмэнжаргал гуайн хашааны хог цэвэрлэх, хашааны зэрлэг өвс зулгаах, ус авч өгөх зэрэг ажлуудыг хийж өгч тусалсан байна.
- ✚ Д.Болормаа багштай 9а анги нь өндөр настан Должин гуайн хашааны хог цэвэрлэх, гэрийн хаяаг манах, аргал түүж өгөх, гэрийн ажлыг хийх, ус зөөж өгөх зэрэг ажлуудыг хийлээ.
- ✚ Б.Ууганцэцэг багштай 10а анги нь өндөр настан Жавзан гуайнд очиж гэр цэвэрлэх, хашааны хог цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж тусаллаа. Мөн өндөр настан С.Нарандэлгэр гуайнд очиж цай чанаж өгөх, хашааны хог цэвэрлэж ачих, гэр цэвэрлэх, эмээдээ сэтгэлийн бэлэг бэлдэж өгсөн улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, Ноён Хутагт Данзанравжаагийн сургаал зэргийг бэлтгэн гарын авлага тараалаа.

- ✚ Г.Энхцэцэг багштай 10б анги нь өндөр настан Хорлоо гуайнд хашааны хог цэвэрлэж өглөө. Мөн өөрсдийн санаачлагаар ангийн сурагч Г. Хонгорзулд аргал түүж өгсөн байна.Сургуулийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй 6 суралцагчдад “Сэтгэлийн давалгаа” аян зохион байгууллаа. /Хавсаргав/
- ✚ О.Оюун багштай 11а анги нь хувиарлагдсан өндөр настан байхгүй байсан учир сайн үйл бүтээн “Үдийн цай” зөөх, бүх багш нарт самбарын алчуур хийж тараах зэрэг ажлуудыг өөрсдийн санаачлагаар хийлээ. Мөн өндөр настан Баасанбат гуайнд хашааны хог цэвэрлэх, эд аж ахуйг нь цэгцлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүмүүнлэгийн 7 хоногийн аяны хүрээнд Соёлын төв

Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 2 дугаар багийн иргэн Баасангийн Оюунчимэгийнд 32500 төгрөгийн эд материалын туслалцаа үзүүлсэн байна. Н.Оюунчимэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 2 хүү, охиныхоо хамт амьдардаг өрх толгойлсон эмэгтэй юм.

Хүмүүнлэгийн 7 хоногийн аяны хүрээнд Цэцэрлэг

Тус сумын 3 дугаар багийн иргэн Оргодол гуайн гэр бүлд ахуйн хэрэгцээний болон хүсний материалын тусламж үзүүлсэн.

Мөн тус цэцэглэгийн “Хэрэмхэн” бүлгийн хүүхдүүдэд 25000 төгрөгний тусламж үзүүлсэн.

Хүмүүнлэгийн 7 хоногийн аяны хүрээнд Ахмадын холбоо

Ахмадын хороо нь хүмүүнлэгийн 7 хоногийн аяны хүрээнд Ахмадуудад гудамж хорооллыг хариуцуулан МУЗН-ийн үүсэл хөгжил, түүний үйл ажиллагааны талаар яриа таниулга хийн ахмадуудаас сайн дурын хандив цуглуулан цугларсан 50,0 төгрөгийг М.Төгсгэрэлийн гэр бүл өгч туслав.

Цаашид олон улсын Улаан Загалмайн өнөөгийн чиг хандлага, Монголын Улаан Загалмайн нийгэмлэгийн үүсэл хөгжил, үйл ажиллагааг сурталчлан, хүмүүнлэгийн арга хэмжээг өргөжүүлэн ажиллах болно.

ТАЙЛАН БИЧСЭН
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.УРАНЧИМЭГ
ХЯНАСАН
ДАРГА Д.ГАНТӨМӨР